



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f [facebook.com/Rtcc.m0n](https://www.facebook.com/Rtcc.m0n)
globe <http://rtcc.mrt.d.gov.mn>
envelope info@rtcc.mrt.d.gov.mn
phone [+976 77244409](tel:+97677244409)

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2018 оны жилийн эцсийн тайлан



2018 оныг “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах жил” болгон зарлаж ажиллалаа

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017.11.20-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2017.11.22-ны өдрийн “Албан даалгавар хэрэгжүүлэх тухай” А/74 дүгээр тушаалаар батлагдсан төлөвлөгөөнд 2018 оныг төвийн хэмжээнд “Сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах жил” болгон зарлаж ажлын цаг ашиглалтад тавих хяналтыг чангатгах, ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнах, бүрэн хариуцах, ажилтны ажлын үр дүнг бодитой, үнэн зөв үнэлж дүгнэх, хөдөлмөрийн дотоод журмыг боловсронгуй болгох зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг шат дараалалтай хэрэгжүүлж ажиллалаа.



Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажилд дэмжлэг үзүүлж ажиллалаа

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллав

Зам, тээврийн хөгжлийн сайдын 197 дугаар тушаалаар Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн шинээр батлагдаж хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу төмөр замын салбарын болон бусад тээврийн байгууллагуудтай уялдах ажиллагаа, салбарын нууцын үйл ажиллагааг хариуцан ажиллалаа.

Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлтээр оруулах, хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах, хуулийн зарим нэр томьёо, үг, өгүүлбэрийг өөрчлөх, хуулийн зарим үг, өгүүлбэрийг хасах гэх мэт нийт 30 хуудас бүхий саналын нэгтгэл болон тайлбар, хуулийн заалтын томьёолол боловсруулж нэмэлтээр тусгах саналыг ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Мөн Сингапур Улсын төмөр замын тухай хууль, БНСУ-ын нислэгийн хөдөлгөөн болон төмөр замын ослыг шинжлэн судлах тухай хууль, Төмөр замын салбарын хөгжлийн тухай хууль,

Логистикийн бодлогын тухай хууль, Төмөр замын барилгын ажлын тухай хууль, Финлянд Улсын төмөр замын тухай хууль, Латви Улсын төмөр замын тухай хууль, Гүрж Улсын төмөр замын тээврийн тухай хуулийг Англи хэлнээс орчуулснаас гадна Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Казакстан Улсын тээврийн тухай хуулийг Монгол хэл рүү орчууллаа. “ОХУ-н төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм”/103 хуудас/, ОХУ-н 2003.02.07 №29 “Төмөр замын тээврийн хөрөнгийг захиран зарцуулах, удирдах онцлогийн тухай” /12 хуудас/, 2001.12.08 өдрийн №266 “БНКУ-н төмөр замын тээврийн тухай хууль” /122 хуудас/ материалуудыг Орос хэлнээс орчуулан, найруулж ЗТХЯ-нд хүлээлгэн өглөө.

Зам, Тээвэр Хөгжлийн сайдын төмөр замын тээврийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг 3-р сард “ГТХЗНТ” УТҮГ-ын албан хаагчидтай уулзаж “Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал төсөл”-д байгууллагын эрх зүйн статусыг тусгах, чиг үүргийг хуульчлан тодорхойлох, төмөр замын тээврийн хөгжлийн бодлого, тулгамдаж буй асуудлуудын талаар харилцан мэдээлэл солилцож, санал хүргүүлэх тухай хэлэлцсэн юм.

Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй дүрэм, журмыг боловсруулах ажлын хэсэгт “ГТХЗНТ”-УТҮГ-ын мэргэжилтнүүд ажиллалаа

Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй дүрэм, журмыг Монгол Улсын Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулахаар Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.01.24-ний 13 дугаар тушаалын дагуу:

1. Төмөр замын дохиолол холбооны журам;
2. Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам;
3. Төмөр замын тээвэр дэх осол, гологдлыг судлан бүртгэх журам;
4. Төмөр замаар ачаа тээвэрлэх журам;
5. Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны журам;
6. Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журам, ажлын цагийн хуваарь, хөдөлмөрийн нөхцөл;
7. Суурь бүтэц, нийтийн болон дагнасан хэрэглээний зам ашиглах, суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч хоорондын хамтран ажиллах болон тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээний үлгэрчилсэн загвар;

8. Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмуудыг шинэчлэн боловсруулаа.

Дээрх журмуудыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Зам тээврийн хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж журмуудын төслийг

боловсруулж олон нийтээс санал авахаар www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудаст байршуулж “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК, ТДС, “ГТХЗНТ” УТҮГ, “УБТЗ” ХНН-ийн ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Төмөр замын аюултай бүсийн дэглэмийн төслийн холбогдолтой баримт бичгийн бүрдүүлэлт хийлээ

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 16 дугаар тушаалаар батлагдсан VII ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж Төмөр замын тээврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8-д заасан “Аюултай бүсийн дэглэм”-ийн төсөлд Тээврийн прокурорын газар, яамны ХШҮДАГ-аас нэмэлтээр ирүүлсэн саналыг тусгаж, Төмөр замын газрын даргын 2009.01.29-ний өдрийн 10 дугаар тушаалаар батлагдсан дэглэмийн заалт тус бүрийг хянаж ТЗДТБХЗГ-аас ирүүлсэн загварт оруулж ЗТХЯ-нд хүлээлгэн өгсөн.



Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн байдлыг ЗТХЯ-нд цаг тухай бүр нь танилцуулж ажилласан

2018 онд хийгдсэн ажлуудаас товч дурдвал:

Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийн байдал, сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн байдлыг ЗТХЯ-ны ХШҮДАГ-т цаг тухай бүр нь тайлагнаж ажиллалаа. 2018 онд төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан, илтгэх хуудсыг 153 дугаартай албан бичгээр ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хүргүүллээ.


Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны “Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих тухай” 23 дугаар тушаалын дагуу 2018 оны II дугаар улирлын байдлаар дотоодын үйлдвэрлэлээс хийсэн худалдан авалтын тайланг албан бичгээр ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өглөө.

“Галт тэрэгний хөдөлгөөний диспетчерийн төлөвлөрүүлэлт ба диспетчерийн хяналтын систем” стандартын төсөл, “Төмөр замын техникийн найдвартай байдал, ерөнхий ойлголт тодорхойлолт” стандартын орчуулгын төсөлд санал боловсруулж ЗТХЯ-нд хүргүүлэв.

Монгол Улсын 2019 оны төсвийн төсөлд “ГТХЗНТ” УТҮГ-аас тусгах саналыг Засгийн газрын 2018 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан төсвийн хязгаарт багтаах удирдамжийн дагуу боловсруулж ЗТХЯ-нд хүргүүлээ.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 169 дүгээр тушаалыг хэрэгжүүлж, “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2018.08.05-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар төвийн 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зам тээврийн хөгжлийн сайдын 146 дугаар тушаалаар үндэсний стандартын баримт бичгийн үзлэгийг зохион байгуулах чиг үүрэг бүхий салбар комиссын бүрэлдэхүүнд орж ажиллан салбарын ажлын хэсгээс гаргасан төлөвлөгөөний дагуу нийт 147 стандартын баримт бичигт үзлэг хийж санал боловсруулж ЗТХЯ-д хүлээлгэн өглөө.





Зам, тээврийн хөгжлийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллалаа

Сайдын шуурхай хуралдаанаас “ГТХЗНТ” УТҮГ-ын өнөөгийн байдал, үйл ажиллагааны талаар танилцуулах, төвийн захирлын тушаал, шийдвэрийн биелэлтийг хянаж, ажлын үйл явцыг тооцож үзэх, өвөлжилтийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хувиар илэрхийлж сайдын шуурхай хуралдаан бүрт танилцуулж ажиллалаа.

Шуурхай ажлын үед ажиллах журмыг тодорхойлох, холбогдох тушаал шийдвэрийг гарган ЗТХЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газарт ирүүлэх, 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтын явцыг БТГ-ын ХОҮХ-т хүргүүлэх, нэгжийн дарга нарын мэдээлэл, сайдын ажиллах хөтөлбөрт тусгах санал, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах саналыг БТГ-т ирүүлэх, сайдын багцын 2018 оны төсвийн гүйцэтгэлийг сайжруулж хөрөнгө оруулалтыг бүрэн ашиглах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах, сайдын шуурхай хуралдаанаас өгсөн биелэгдээгүй үүрэг, даалгаврын биелэлтийг ТЗУГ-ын шуурхай хуралдаан хариуцсан мэргэжилтэнтэй тулгалт хийж бүрэн дуусгасан.

Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах технологийн шийдлийг нэвтрүүлэх чиглэлээр төмөр замын байгууллагуудтай зөвшилцөн төвийн захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж хөдлөх бүрэлдэхүүн хянах “RFID” систем нэвтрүүлэх талаар санал боловсруулж ЗТХЯ-нд хүргүүллээ.



“ГТЗХНТ” УТҮГ хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох, улсын бүртгэлд хамруулах үйл ажиллагааг тогтмол явуулж байна

“ГТХЗНТ” УТҮГ нь “Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам” MNS 6630-1,2,3,4:2016 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2018 оны 12-р сарын 28-ны байдлаар “ГТХЗНТ” УТҮГ нь Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох ажлыг зохион байгуулах, бүртгэх, эрх бүхий хуулийн этгээдийг мэдээллээр хангах ажлын хүрээнд төмөр замын тээвэрт оролцогч 5 компаниудын эзэмшлийн 659 хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгон, нийт 220 хөдлөх бүрэлдэхүүнд дугаарын баталгаажуулалт хийж улсын бүртгэлд хамруулсан байна.

Суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийж байна

Төмөр замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д заасан төвийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой “Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам”-ын 6.1, 6.5 дахь заалтыг хэрэгжүүлж галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах, суурь бүтцийн тээх, нэвтрүүлэх чадвар, суурь бүтэц эзэмшигчийн хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтад хяналт тавих зорилгоор суурь бүтэц дэх 2018 оны өвөл, зуны цагийн хуваарийн галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд /төмөр замын тээврийн чанарын үзүүлэлт/ шинжилгээ хийж, шинжилгээний тайлан, зөвлөмжийг боловсруулж “Улаанбаатар төмөр зам” ХНН-т, ажлын үр дүнг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт танилцуулсан. 2018 оны 1-12 дугаар сарын галт тэрэгний зурмагийн тасалдлын мэдээ, тайлан боловсруулсан.





Монгол улсын төмөр замын тээврийн салбарт ашиглагдаж буй ачааны вагоны нэгдсэн тооллого хийлээ

Төмөр замын салбарын тээвэрлэлтэд ашиглагдаж буй нийт ачааны вагоны бүртгэлийн зөрчлийг арилгах, нэгдсэн мэдээллийн санг шинэчлэх, онлайн бүртгэлд шилжих, гадаад, дотоод, вагоны тоо, төрөл, зориулалтыг нарийвчлан тогтоох зорилгоор ачааны вагоны нэгдсэн тооллогын ажлыг ЗТХЯ-наас зохион байгууллаа. Уг ажлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 5 сарын 22-ны өдрийн 109 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн ахлагчаар “ГТХЗНТ” УТҮГ-ын захирал Т. Ариунбаатар ажиллалаа.

Монгол улсын төмөр замын тээврийн салбарт ашиглагдаж буй ачааны вагоны нэгдсэн тооллого хийж вагоны баримт бичгийг бодит байдалтай нь тулгах, вагон ашиглалтын баримт бичгийг бүртгэлжүүлэн мэдээллийн сан бүрдүүлэн хяналт тавьж судалгаа, дүгнэлт гаргаж ажиллалаа

Нэгдсэн тооллогод “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК, “Тээвэр зуучийн төв”, “Хөтөл цемент шохой” ХХК, “Тэгш Термес” ХХК, “Туулын гүүр далай” ХХК, “Энжелик” ХХК, “Эрдэнэт Үйлдвэр” ХХК, “Эрэл” ХХК, “Баян-Эрдэнэ” ХХК, “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК, “Монцемент Билдинг материалс” ХХК, “Сонголон Бармат” ХХК, “МАК цемент” ХХК, “Эко Могул” ХХК, “Зураг төслийн институт” ХХК болон бусад вагоны эзэмшигч, өмчлөгч иргэн, аж ахуй нэгжүүд хамрагдсан юм

Төвийн мэдээллийн нэгдсэн санд ачааны вагоны ажлын паркард нийтдээ 7053 вагон бүртгэгдсэнээс “УБТЗ” ХНН-ийн эзэмшлийн 3300 вагон, бусад эзэмшигчийнх 3753 вагон бүртгэгдсэн байна.



Олон Улсын стандарт, барим бичгүүдийг орчуулан боловсруулав

“ГОСТ 33435-2015 Хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй ажиллагаа, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж. Аюулгүй ажиллагааны шаардлага ба хяналтын арга” болон “О+Р 941 - “Мэдээллийн сан болон мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдал”, “ГОСТ Р 54115-2010-“Глобал навигагийн хиймэл дагуулын систем. Нийтийн хэрэглээний төмөр замын хүлээн авагч. Техникийн шаардлага” гэсэн стандартуудыг Орос хэлнээс Монгол хэл рүү орчуулж төмөр замын салбарын байгууллагуудын саналыг авч нэгтгэн боловсруулсан.

“Төмөр замын ачааны вагоны үйлдвэрлэлийн объект ТВ 10031-2009” 58 хуудас стандартыг Хятад хэлнээс орчууллаа. Стандартын төсөлд ТЗДТБХЗГ, ХШУДАГ, “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК, ТДС-аас тус тус саналыг тусган Төмөр зам, далай ашиглалт ба усан замын тээврийн стандартчиллын Техникийн хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлээд байна.

Азийн Хөгжлийн банкнаас санхүүжүүлж буй Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь “Бүс нутгийн Логистикийн төв” барих ажлын Зам, тээврийн хөгжлийн яам /Захиалагч/ болон Soosung engineering бүрэлдэхүүнд нь Soosung Engineering ХХК, Geo Zuraglal ХХК, NBCC ХХК, /Зөвлөх/ нарын хооронд байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээг ажлын даалгаврын хамтаар орчуулж ЗТХЯ-нд хүлээлгэн өглөө.

3.3.1.1. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.1.2. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.1.3. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.1.4. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.1.5. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.1.6. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.1.7. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.2.1. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.2.2. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.2.3. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.2.4. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.2.5. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.2.6. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.2.7. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.

3.3.2.8. Энэ стандартын үйлдвэрлэлийн объектын үйлдвэрлэл, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахад зориулагдсан.



Төмөр замын салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна



Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 01/92 дугаар тушаалаар батлагдсан улсын

тайлан Т-9 маягтын дагуу төмөр замын тээврийн 2018 оны 1-11 дүгээр сарын статистик мэдээг нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, зорчигч болон ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtd.gov.mn, төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангаж ажиллалаа.

“Улаанбаатар төмөр зам” ХНН-аас Тээвэрлэлтийн захиалгын мэдээ, Зорчигч тээвэрлэлтийн мэдээ, Вагоны парк ашиглалтын мэдээ /суудал/, Вагоны парк ашиглалтын мэдээ /ачаа/, Зүтгүүрийн парк ашиглалтын мэдээ, “Монголын төмөр зам” ТӨХК-аас Вагоны парк ашиглалтын мэдээ /ачаа/, Зүтгүүрийн парк ашиглалтын мэдээ, Ачилтын мэдээ /ачааны төрлөөр, өссөн дүнгээр/, “Болд төмөр ерөө гол” ХХК-аас Вагоны парк ашиглалтын мэдээ /ачаа/, Зүтгүүрийн парк ашиглалтын мэдээ, Ачилтын мэдээ /ачааны төрлөөр, өссөн дүнгээр/ хоногийн болон 7 хоног, сар бүрийн мэдээг тогтмол авч мэдээллийн нэгдсэн санд бүрдүүлж байна.

2018 онд мэдээллийн нэгдсэн санд хоногийн 2827, сарын 116, улирлын 33, хагас жилийн 6, жилийн 22, нийт 3004 мэдээг бүрдүүлж төвлөрүүлсэн байна. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс бүрдсэн мэдээллүүдийг цаг тухай бүр зөөврийн санах төхөөрөмжинд байршуулж байна.



Хөдлөх бүрэлдэхүүний хяналтын шийдлийг судлав

Хөдлөх бүрэлдэхүүний хяналтын шийдэл буюу “RFID” буюу радио соронзон долгион ашиглан хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэх, хянах чип (CHIP), шошго (TAG) зэрэг шийдлүүдийг судалж танилцуулга



бэлтгэж төмөр замын байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулан хяналтын системүүдийн шийдэлд санал авч боловсруулан ЗТХЯ-нд хүргүүлээ. Тус ажилтай холбоотойгоор “УБТЗ” ХНН-ийн Сүхбаатар өртөөнд суурилуулсан “АСКО ПВ” хяналтын камерийн системийн үйл ажиллагаа, программ хангамжтай танилцлаа. Томилолтын ажлын үр дүнд судалгаанд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн үнэ болон ажиллах горимын давуу болон сул талуудыг шинжлэн үнэлэлт дүгнэлтийг гаргалаа.



Гадаад харилцаа, хамтын ажиллагаа



**Япон улсын “ЖЕТ Коннект” ХК-тай хамтран ажиллах
санамж бичиг байгууллаа**

Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын захирал Т.Ариунбаатар, Япон улсын “ЖЕТ Коннект” ХК-ийн захирал Эики Шигета нар хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. Тус санамж бичигт тодорхой цэгүүд дэх хөдлөх бүрэлдэхүүнийг удирдан зохицуулах системийг хөгжүүлэх; Монгол улсын галт тэрэгний хөдөлгөөн удирдлага, зохицуулалтыг хөгжүүлэх, судалгаа хийх; төмөр замын тээвэрлэлтийн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд шинэ технологи нэвтрүүлэх замаар дэмжлэг үзүүлэх; техникийн хамтын ажиллагааны хүрээнд түншлэлийг бий болгох; Япон улсын холбогдох байгууллага, компаниудтай хамтран ажиллах чиглэлээр холбоо тогтоож, дэмжлэг үзүүлэх зэрэг төлөвлөгөөнүүд тусгагдсан.

Санамж бичиг байгуулагдсанаар систем хөгжүүлэлтийн чиглэлээр “ЖЕТ Коннект” ХК нь “ГТХЗНТ” УТҮГ-ыг Япон улсын туршлага дээр суурилсан системээр төдийгүй галт тэрэгний хөдөлгөөн удирдлагын хүрээнд техникийн туслалцаа, зөвлөгөөгөөр хангах, Япон улсын төмөр замын оператор компаниудтай зөвлөлдөж тэдний туршлага дээр үндэслэн төвийн инженер, албан хаагчдыг сургаж ажиллах юм.

*Төмөр замын салбарын холбогдолтой гадаад улсын
этгүүлийг төвийн сайтаас татаж авах боломжтой*



Төвийн цахим хуудсанд “Railway illustrated”, “The railway magazine”, “Modern railways”, “Rail Express”, “Model Railway”, British Railway Modelling”, “Railway Digest” этгүүлүүдийн 2018 оны 1 сараас 12 сарын дугаарыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн www.rtc.mtrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэлээ.

“RailwayDigest” этгүүлээс Олон улсын өндөр хурдны төмөр зам, “Railway Magazine” этгүүлээс төмөр замын цэцэрлэгт хүрээлэнгийн тухай мөн “Симс” компанийн сүүлд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр зэрэг сонирхолтой мэдээ мэдээллийг харах боломжтой.





БНХАУ-д “Төмөр замын төлөвлөлт ба бүтээн байгуулалтын менежмент” семинарт хамрагдлаа

“ГТХЗНТ” УТҮГ-ын салбарын судалгааны мэргэжилтэн 2018 оны 8 дугаар сарын 29-өөс 9 дүгээр сарын 20-ны хооронд БНХАУ-ын Чендү хотод болсон Хятадын Худалдааны Яамнаас зохион байгуулсан “НЭГ БҮС НЭГ ЗАМ” төсөлд оролцогч орнуудын мэргэжилтнүүдийг хамруулсан “Төмөр Замын төлөвлөлт ба бүтээн байгуулалтын менежмент” семинарт “Seminar on Railway Planning and Construction Management” оролцсон.


Мөн БНХАУ-ын Худалдааны яам, Сужоугийн Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль хамтран хөгжиж буй орнуудын тээвэр, логистикийн салбарын мэргэжилтнүүдэд зориулан зохион байгуулсан “Логистикийн хөгжил, удирдлага” сэдэвт сургалтад төвийн мэргэжилтнүүд хамрагдлаа.





“УБТЗ” ХНН-ийн Замын үүд, Сайншанд, Айраг, Бор-Өндөр Чойр өртөөнд албан томилолтоор ажиллалаа

ОХУ- Монгол- Хятад улсын ачааны хэмжээ тогтоох хуралд “ГТХЗНТ” УТҮГ-ын Захирал Т. Ариунбаатар оролцлоо. Мөн шугам замын урд хэсэгт хуримтлагдсан ачааны бөөгнөрлийн хэмжээ, нөхцөл байдлыг газар дээр нь судлан дүгнэлт гаргаж, галт тэрэг, ачаа, хөдлөх бүрэлдэхүүний солилцоо хийгдэж буй ажилтай танилцах, ачааны баримт бичиг бүрдүүлэлт, ачаа эргэлт, хэсгийн хурд, зүтгүүр вагоны хуваарилалтыг судлах зорилгоор 2018 оны 1 дүгээр сард Замын-Үүд, Сайншанд, Айраг, Бор-Өндөр, Чойр өртөөдөд албан томилолтоор ажиллалаа.




2018 оны 5 дугаар сард “УБТЗ” ХНН-ийн Замын Үүд, Сайншанд, Чойр, БНХАУ-ын Хөх хотын төмөр замын Эрээн өртөөнүүдэд ХЗХБХ-ийн суурь бүтэц хариуцсан ахлах мэргэжилтэн, ТМССХ-ийн сургалт, судалгааны ахлах мэргэжилтэн нарын хамтаар “УБТЗ” ХНН-ийн Замын-Үүд өртөөнд үүсээд байгаа ачааны вагоны хүрэлцээгүй байдал, замын хэмжээнд 4200 вагон ачаа хуримтлагдсан түүний дотор чингэлэг вагон ихэнх хувийг эзэлж байгаа шалтгаан нөхцөлийг судлан, шалгаж шийдвэрлэх арга хэмжээний талаар санал боловсруулахаар ажиллалаа.

2018 оны 9 дүгээр сард “УБТЗ” ХНН-ийн Баянтүмэн тасагт томилолтоор ажиллаж тасгийн үйл ажиллагаа болон зурмагийн биелэлт, салбар замуудтай танилцсан юм.



Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хаврын хэлэлцүүлэгт амжилттай оролцлоо


Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хаврын хэлэлцүүлэг 2018 оны 3 дугаар сарын 28-нд Төрийн ордонд “Хүчээ нэгтгэе” гэсэн уриатайгаар зохион байгуулагдлаа. Төрийн ордны “Их танхим”-д болсон нэгдсэн хуралдаанаар “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” илтгэлийг Монгол улсын сайд, ЗГХЭГ-ийн дарга Г.Занданшатар, “Татварын хуулийн шинэчлэл” илтгэлийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар тавьж хэлэлцүүлэв. Хэлэлцүүлэгт төвийн төлөөлөл оролцож илтгэгч болон панелистуудтай өөрсдийн санал бодлоо солилцож, харилцан нээлттэйгээр оролцлоо.





NEWS “Төмөр замын хөгжил, салбарын ажилтнуудын нийгмийн асуудал” сэдэвт зөвлөгөөн зохион байгуулагдлаа.

Монгол Улсад төмөр замын салбар үүсэж хөгжсөний 80 жилийн ой энэ онд тохиож буй. Уг тэмдэглэлт баярыг угтан “Төмөр замын хөгжил, салбарын ажилтнуудын нийгмийн асуудал” сэдэвт зөвлөгөөн амжилттай зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнд “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын захирал Т.Ариунбаатар: “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн үйл ажиллагаа, хэтийн төлөв” сэдвээр илтгэл тавьсан юм. Тус зөвлөгөөнд төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл, аж ахуйн нэгжүүдийн удирдлагууд, төмөр замын салбарын нийт 800 гаруй зочид төлөөлөгчид оролцсон юм.





Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд 80 мод тарилаа

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг энэ оны тавдугаар сарын 12-ны өдөр 9 дэх жилдээ зохион байгуулсан. Уг аяны хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, “УБТЗ” ХНН-ийн мэргэжилтнүүдтэй хамтран Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд 80 ширхэг мод тарилаа.





Төвийн албан хаагчид сургалт, мэдээллийн арга хэмжээнд тогтмол хамрагдаж байна

2018 онд “Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенц”, “Жендер”, “Төрийн болон албаны нууцын тухай хууль”, “Авлигын шалтгаан түүний үр дагавар”, “Ажил олгогч, удирдах ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа”, “Төмөр замын ерөнхий зохион байгуулалт” гэх мэт нийт 20 сургалтад тус тус хамрагдсан байна.

Мөн Хан-Уул дүүргийн “Албан бус-Насан туршийн боловсролын үндэсний төв”-тэй хамтран ажиллаж хувь хүний хөгжлийн сургалтуудад тогтмол хамрагдаж салбарын спортын арга хэмжээнд баг хамт олноороо идэвхтэй оролцож байна.






Зам, тээврийн салбарын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцлоо

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг Зам, тээврийн салбарын аварга шалгаруулах спортын таван төрөлт тэмцээн 4 сарын 7-ны өдрөөс эхлэн 24-ний өдрүүдэд болж өнгөрлөө. Зам, тээврийн хөгжлийн яам, түүний харьяа байгууллагуудын ажилтан, албан тушаалтнуудыг хамарсан тус спортын таван төрөлт тэмцээн нь идэвхтэй хөдөлгөөнөөр бие бялдраа чийрэгжүүлэх цаашлаад ажлын бүтээмж нэмэгдүүлэх, салбарын ажилтнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, спортын идэвхийг нэмэгдүүлэх зорилготой.

Тэмцээн Дартс, Снукер Бильярд, Хөлбөмбөг, Гар бөмбөг, Сагсан бөмбөг гэсэн төрлүүдээр зохион байгуулагдсан. Уг тэмцээнд ЗТХЯ-ны харьяа байгууллагын нийт 450 орчим тамирчид оролцсон ба “ГТХЗНТ” УТУГ-ын албан хаагчид хурд хүч, авьяас чадвараараа өрсөлдөж амжилттай оролцлоо.





 8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
3-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс

